

БАТЛАВ.
ЭДИЙН ЗАСГИЙН
ХӨГЖЛИЙН САЙД

Н.БАТБАЯР

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙН САЙД

Х.ТЭМҮҮЖИН

ОЛОН ТАЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ БАТАЛГААЖУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН КОНВЕНЦИД ОРСОН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ, СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

1. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улс нь Дэлхийн банкны бүлгийн гишүүн байгууллага - Олон талын хөрөнгө оруулалтыг баталгаажуулах байгууллага (ОТХОББ)-ын Конвенцид 1991 оны 6 дугаар сарын 14-ний өдөр гарын үсэг зурж, Улсын Их Хурал 1998 оны 7 дугаар сарын 23-ны өдөр соёрхон баталснаар гишүүн орон болсон.

ОТХОББ-ын Конвенцийн 59, 60 дугаар зүйлд заасны дагуу энэхүү конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төслийн талаар Захирагчдын дунд санал хураалт явуулснаас 150 гишүүн орны 193315 санал буюу 88,3%-ийн дэмжлэг авч, нэмэлт, өөрчлөлтийг 86 дугаар тогтоолоор батлан 2010 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж байна.

Уг тогтоолоор Конвенцийн "11. Баталгаанд хамаарах эрсдэл", "12. Баталгаа гаргаж болох хөрөнгө оруулалт" зүйлүүдэд баталгаа гаргах зээлийн хамрах хүрээг өргөжүүлж, хөрөнгө оруулагчид баталгаа гаргах үйл явцыг хялбарчилж, нэмэлт хөрөнгө оруулалтыг баталгаанд хамруулах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна.

2. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх ба Олон талын хөрөнгө оруулалтыг баталгаажуулах байгууллагын Конвенцид орсон нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай заалт байна.

3. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийг соёрхон баталснаар Дэлхийн Банкны бүлгийн гишүүн байгууллага – ОТХОББ-аас Монгол Улсад явуулах үйл ажиллагааны хамрах хүрээ өргөжих эрх зүйн орчин бүрдэнэ. Мөн манай улсад бизнес эрхэлж буй болон шинээр орж ирэх хөрөнгө оруулагчид томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхдээ ОТХОББ-аас баталгаа гаргуулах боломж бүрдэж, хөрөнгө оруулагчдын итгэл, баталгаат байдлыг нэмэгдүүлж, улмаар гадаадын хөрөнгө оруулалтын урсгал нэмэгдэх юм.

4. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаархи санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай хууль болон бусад хуультай нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөл батлагдсанаар шинээр хууль боловсруулах, бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шаардлагагүй.

oOo